



ЭМД

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

**Эрүүл мэндийн даатгалын
санхүүжилтийн шинэчлэл**

САНХҮҮЖИЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГО



ЗОРИЛГО

Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ бүрэн хариуцах


Шаардлагагүй хэвтэлт, үр ашиггүй тусламж, үйлчилгээг бууруулах

Төвлөрлийг сааруулах

Эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах

ҮР ДҮН /2023/

ЭМДС-ийн үр ашигт байдал



01

02

03

04

№	Төвлөрөл саарч нэн шаардлагатай ТҮ-г үзүүлдэг байгууллагын тоо өссөн	2021 он	2022 он	2023 он	Өсөлтийн хувь
1	Хорт хавдар хими, бай	13	16	30	130.8%
2	Хорт хавдар хөнгөвчлөх	26	37	41	57.7%
3	Хорт хавдар мэс засал	5	20	38	660%
4	Гэмтлийн яаралтай тусламж	20	53	41	105.0%
5	Гэмтлийн мэс засал	42	46	42	0%
6	Яаралтай тусламж	54	62	61	13.0%

№	Хамтын төлбөрөөс чөлөөлөх бүлэг	Хамтын төлбөрөөс чөлөөлсөн дүн 2022 он	Хамтын төлбөрөөс чөлөөлсөн дүн 2023 он
1	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн	3.26	6.3
2	Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн	30.69	39.4
3	Ял эдэлж байгаа ялтан	0.05	0.04
4	0-18 насны хүүхэд	10.12	15.1
5	Хугацаат цэргийн албан хаагч	0.04	0.1
6	Хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл өсгөн бойжуулж буй эх, эцэг	2.97	1.9
Нийт		47.16	62.81

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

- Амбулаторийн тусламж, үйлчилгээний чанар хангалтгүй, тоо хэмжээ хөөж сонирхол их байна. Амбулаторийн хүлээгдэл буурахгүй байна.
- Орон нутагт тусламж, үйлчилгээг чанартай үзүүлэх чадамж хангалтгүй байна. Бүс нутагтаа хэрэгцээтэй тусламж, үйлчилгээг үзүүлэхгүй байна.
- Эмнэлгийн хэт илүүдэл, орны тоо нь ЭМД-ын хөрөнгийг үр дүнгүй зүйлд зарцуулах нөхцөл болж байна. Эмнэлэгт хэвтэлтийн тоо хэмжээ буурахгүй байна.
- Шинэ технологийг шууд ЭМДС-аас санхүүжүүлэх хүсэлт их байна.



- Монгол улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар 2024 оны 04 сарын 01-ний өдрөөс цалин хөлс, орон нутгийн нэмэгдэл хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотой Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсөвт 96 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд энэхүү **цалингийн нэмэгдлийг ОХБ-ийн тарифт тусгах**

- Тогтоолыг хэрэгжүүлэх явцад эрүүл мэндийн байгууллагуудаас тусламж, үйлчилгээний тарифыг нэмэгдүүлэх, өртгийг дахин тооцох, зарим онош, үйлдлийг багцад нэмэх, ОХБ-ийг оновчтой тогтоох зэрэг саналууд ирж буй тул тэдгээр саналуудыг судалж, **нэмэлт судалгаа, өртгийн тооцоолол хийсний үр дүнд шаардлагатай** өөрчлөлтүүдийг хийх хэрэгцээ тулгарсан.



- ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолоор амбулаторийн хяналтын багцыг өргөжүүлснээр нийт амбулаторийн 19 ОХБ бий болж өргөжсөн. Ийнхүү амбулаторийн багц өргөжсөний үр дүнд иргэн, даатгуулагч төрийн болон хувийн эмчийн эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлж, амбулаторийн тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, 2022 онтой харьцуулахад 2023 оны гүйцэтгэл 40 хувиар буюу 2,1 сая тохиолдлоор нэмэгдсэн байна. **Гэвч дээрх өөрчлөлтөөр тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн нь сайн үзүүлэлт боловч тохиолдол бүрээр амбулаторийн үзлэгийг санхүүжүүлж буй одоогийн тогтолцоо нь иргэн, даатгуулагчийн эрүүл мэндийн асуудлыг богино хугацаанд шийдэж, эцэслэхгүй, хүлээгдэл буурахгүй байна.** Амбулаторийн тусламж үйлчилгээний ОХБ-т өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг тохиолдол тус бүрээр санхүүжүүлж байгаа нь эрүүл мэндийн байгууллагуудад тоо хэмжээ хөөх сонирхолыг өдөөж, амбулаторийн тусламж, үйлчилгээг иргэн, даатгуулагчдад иж бүрэн цогцоор нь үзүүлэхгүй хүлээгдэл их байна.






ЭМД

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

**АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙН
БОДЛОГО, ЗОРИЛТ**


ЭМДСангийн төсвийн хуваарилалт



- Лавлагаа шатлал эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилт
- Анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилт
- Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг оношилгоо
- Эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилт
- Бусад

Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд зарцуулах санхүүжилтийг бууруулж, Анхан шатны тусламж, үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлтийн төсвийг нэмэгдүүлэх бодлого баримталж байна.

АНХАН ШАТНЫ ЭМБ-УУДАД ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ /тэрбум төгрөгөөр/



Олгосон санхүүжилт 2021-2023 он /тэрбум төгрөгөөр/



Төрөлжсөн
мэргэжлийн эмнэлэг

Аймаг, дүүргийн
нэгдсэн эмнэлэг

Анхан шат



1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн өрхийн эрүүл мэндийн төвүүд болон сум, тосгоны эрүүл мэндийн төвийн албан хаагчдын Засгийн Газраас баталсан үндсэн цалинг 10 хувиар өсгөж, орон нутгийн нэмэгдлийг 40 хувьд хүргэх холбогдох тооцооллыг тусгалаа.

Төсвийг тооцох томъёо:

$$\text{НИС} = \sum_{k=0}^n \binom{n}{k} \text{ХАК} \times \text{ТАР} \times \text{ГЗК} \times \text{ОНН}$$

НИС – нэг иргэнээр тооцсон суурь төсөв

ХАК – хүн амын эрсдэлийн бүлгийн коэффициент

ТАР – нэг иргэнд ногдох зардлын хэмжээ

ОНН – орон нутгийн цалингийн нэмэгдлийн коэффициент

ГЗК – газар зүйн коэффициент

- Үйлчлэх хүрээний радиус
- Аймгийн төвөөс алслагдсан байдал
- Замын бартаа, хүндрэл
- Хүн амын тэгш байдлын индекс
- Тэнцвэржүүлэгч коэффициент-0.5

Орон нутгийн цалингийн нэмэгдлийн коэффициентыг журмын хавсралтаар баталсан хэмжээгээр анхан шатны эрүүл мэндийн байгууллага бүрээр тооцно.

ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 тогтоолын шинэчилсэн төсөлд:

ЭМД-ЫН САНГААС ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ НЬ ХАРИУЦАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХОД БАРИМТЛАХ ОРОН НУТГИЙН ЦАЛИНГИЙН НЭМЭГДЛИЙН ИНДЕКС

№	Орон нутгийн төрөл	Нэмэгдлийн индекс
1	Сум, тосгоны эрүүл мэндийн төв, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	1.18
2	Орхон аймаг /Жаргалант сум/ Өрхийн эмнэлгүүд 1,06	2.04



Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасан өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээг өргөжүүлж хүүхдийн өдрийн эмчилгээний багц, хүүхдийн халдварт бус суулгалт өвчний багцуудыг шинээр үүсгэж лавлагаа шатлалын ачааллыг бууруулах, анхан шатандаа хүртээмжтэй тусламж, үйлчилгээг авах;



**Өдрөөр үзүүлэх
эмийн эмчилгээ
120,000**



**Хүүхдийн амьсгалын
замын үрэвсэлт өвчин
80,000**




**Хүүхдийн халдварт бус
суулгалт өвчин
60,000**

ЭМД-ЫН ТУХАЙ ХУУЛИЙН 9.1.9-Д ЗААСАН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН БОЛОВЧ ШААРДЛАГАТАЙ ХҮНДЭЭ ХҮРЧ ҮЙЛЧЛЭХГҮЙ БАЙНА.

АСУУДАЛ:

2023 ОНД ГЭРЭЭР ҮЗҮҮЛЭХ ТҮ АВСАН ДААТГУУЛАГЧДЫГ ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН ТӨРЛӨӨР ЗАДЛАВАЛ



ШИЙДЭЛ:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасан гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний багцыг өргөжүүлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч чадахгүй байгаа иргэд буюу хөнгөвчлөх тусламж үйлчилгээ болон хүүхэд, тулгуур эрхтэний хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмнэлэгт ирэх боломжгүй ахмад настанд зайлшгүй үзүүлэх тусламж, үйлчилгээг шинээр үүсгэсэн.



Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ /Z51.5/ 150,000




Эмнэлэгт ирэх боломжгүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхдэд зайлшгүй үзүүлэх тусламж, үйлчилгээ 100,000



Бусад гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ 50,000

Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн нэг иргэнээр авсан тусламж, үйлчилгээ





Анхан шатны тусламж, үйлчилгээг өргөжүүлж, хүүхдэд хүртээмж нэмэгдэх;

Лавлагаа шатлал руу хүнд хэлбэрээр очих хүүхдийн урсгал бууруулах;

Дархлаажуулалтын үр дүн дээшилж, үр дүнтэй цаг хугацаанд нь дархлаажуулахад анхан шат илүү анхаарна.

ЭМДС-ын үр ашиг дээшлэх, халаасны төлбөр буурна.




ЭМД

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

**ЛАВЛАГАА ШАТНЫ ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙН
БОДЛОГО, ЗОРИЛТ**

#	Тусламж, үйлчилгээний төрөл	ЭМДҮЗ 08 –р тогтоол дээрх ОХБ –ийн тоо	Шинэ төсөл дээрх ОХБ –ийн тоо	Өөрчлөлтүүд
1	Амбулаторийн тусламж, үйлчилгээ	20	37	Амбулаторийн тусламж үйлчилгээний оношийн хамааралтай бүлэгт өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээг тохиолдол тус бүрээр санхүүжүүлдэг байсан нь эрүүл мэндийн байгууллагуудад тоо хэмжээ хөөх сонирхолыг өдөөж байсан тул оношийн хамааралтай бүлгийн зарчмын дагуу тухайн тусламж, үйлчилгээг цогцоор нь үзүүлэх зарчмыг баримталж шинээр амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээг нэгтгэн шинээр багц үүсгэсэн.
2	Амбулаторийн өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	9		
3	Өдрийн эмчилгээ	1	55	Хорт хавдрын химийн бай эмчилгээнд хэрэглэдэг эм нийлүүлэлтийн монополь байдлаас хамаарч зах зээлийн үнэ тасралтгүй нэмэгдэж байгаа тул тухайн багцаас эмийг салгаж Засгийн газрын тогтоолоор нэг худалдан авагчийн эх үүсвэрээр худалдан авах тогтолцоонд шилжүүлэх замаар санхүүжилтийн үр ашигтай байдлыг дэмжиж бодлогын тохируулга хийж ажилласан. Мөн байнгын эмчийн хяналтад удаан хугацааны нөхөх эмчилгээний эмийн жагсаалтаас хэрэглэсэн эмийг тусад нь санхүүжүүлэхээр заасан.
4	Бусад өдрийн эмчилгээ	11		
5	Өдрийн мэс засал	60		
6	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	575	556	Өөрчлөлтгүй. 45 ОХБ болгосон.
7	Хөнгөвчлөх	1	1	Эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийг задалж, үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын гүйцэтгэлээр нь 4 ялгаатай оношийн хамааралтай бүлэг болгон хуваасан. Ингэснээр эмнэлзүйн удирдамж зааврын дагуу иргэн, даатгуулагчдад шаардлагатай тусламж, үйлчилгээг иж бүрэн үзүүлсэн байхыг дэмжиж санхүүжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн.
8	Телемедицин	1	1	Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.7-т “удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардал”-ыг төрөөс хариуцахаар заасны дагуу Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/407 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж энэхүү тогтоолын хавсралтаар төрөөс төлбөрийг 100% хариуцсан санхүүжүүлэх журам, эмийн жагсаалтыг батлуулахаар төсөлд тусгасан.
9	Уламжлалт	16	16	Сэргээн засах тусламж үйлчилгээг хурц үеийн тусламж үйлчилгээний дараа авсан тохиолдолд санхүүжүүлэх бөгөөд гарсан үр дүнгээс нь хамаарч санхүүжилтийг үргэлжлүүлэх эсэхийг шийдэж, дэмжиж санхүүжүүлэхээр тус тус зохицуулсан.
10	Сэргээн засах	12	9	Өөрчлөлтгүй
11	Түргэн тусламж	5	5	Өөрчлөлтгүй
12	Яаралтай тусламж, үйлчилгээ	6	6	Дахин багцалсан.
13	Сувилаас тусламж, үйлчилгээ	1	3	

КТ – ЭЕРЭГ ХУВЬ




Амбулаториор хийгдэж байгаа КТ оношилгооны эерэг хувь дунджаар 8%, нийт гэрээт ЭМБ-ын 71%-д тухайн оношилгооны эерэг хувь 10-аас бага хувьтай байна.

Дүрс оношилгооны эерэг хувь эрт илрүүлгийн шинжилгээнд 1-10 хувь, оношилгооны зорилгоор хийгдэж буй шинжилгээнд 10-50 хувь, яаралтай хийгдэж буй шинжилгээнд 50-иас дээш хувьтай байдаг.


Амбулаториор хийгдэж байгаа MRI оношилгооны эерэг хувь дунджаар 5%, бүх гэрээт ЭМБ-дад тухайн оношилгооны эерэг хувь 10 ба түүнээс бага хувьтай байна.

Тодорхой эмгэгийн үед илрэх өөрчлөлтийг дүрс оношилгоогоор илрүүлсэн хувийг эерэг хувь гэнэ.

MRI – ЭЕРЭГ ХУВЬ



КТ – ЭЕРЭГ ХУВЬ




Амбулаториор хийгдэж байгаа КТ оношилгооны эерэг хувь дунджаар 8%, нийт гэрээт ЭМБ-ын 71%-д тухайн оношилгооны эерэг хувь 10-аас бага хувьтай байна.

Дүрс оношилгооны эерэг хувь эрт илрүүлгийн шинжилгээнд 1-10 хувь, оношилгооны зорилгоор хийгдэж буй шинжилгээнд 10-50 хувь, яаралтай хийгдэж буй шинжилгээнд 50-иас дээш хувьтай байдаг.

Амбулаториор хийгдэж байгаа MRI оношилгооны эерэг хувь дунджаар 5%, бүх гэрээт ЭМБ-дад тухайн оношилгооны эерэг хувь 10 ба түүнээс бага хувьтай байна.

Тодорхой эмгэгийн үед илрэх өөрчлөлтийг дүрс оношилгоогоор илрүүлсэн хувийг эерэг хувь гэнэ.

MRI – ЭЕРЭГ ХУВЬ



1. Нэг хүний оношилгоо, шинжилгээний хэрэглээг тооцох



2. Нэг хүний хэрэглээний өртөг тооцох




3. Онош бүрийн өртгийг бүлэглэж тооцох



Бодлогын гол өөрчлөлт:


Өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээг амбулаторийн үзлэг, хяналтын багцад нэгтгэж, “Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ”-ний багцыг шинээр бий болгосон.



Бодлогын гол өөрчлөлт:



70 хувь буюу
105.560



Нийт ЭМБ-ын гаргасан зардал 70 хувиас их бол тогтоолын өртгөөр гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.



Нийт ЭМБ-ын гаргасан зардал 70 хувиас бага бол бодит гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.



Жирэмсний хяналтын үзлэг

Бодлогын гол өөрчлөлт:



60,000₮

60,000₮

60,000₮

60,000₮

12 долоо хоногийн
дотор

20 долоо
хоног

24 долоо
хоног

28 долоо
хоног

32 долоо
хоног

36 долоо
хоног

38 долоо
хоног

39-40 долоо
хоног

60,000₮

60,000₮


60,000₮

60,000₮

ЭМСайдын 2020 оны
А/318 тушаалын дагуу
хийгдсэн шинжилгээг
зайлшгүй үзүүлсэн
шинжилгээг нэмэлтээр
санхүүлнэ.

ЭМСайдын 2020 оны
А/318 тушаалын дагуу
хийгдсэн шинжилгээг
зайлшгүй үзүүлсэн
шинжилгээг нэмэлтээр
санхүүлнэ.

Тулгамдсан асуудал:



- Трастузумаб, бевацизумаб, дабрафениб, gefitinib зэрэг 16-20 төрлийн хавдрын эсрэг 1.500.0-4.500.0 нэгжийн ялгаатай үнэтэй эмүүд хавдрын бай эмчилгээнд хэрэглэгдэж байна.
- Судалгаагаар нийт химийн эмчилгээнд ашиглаж буй эмийн зардлыг тооцож санхүүжүүлж буй тариф өртөгтэй харьцуулахад хэт бага эсвэл өндөр үнэтэй эм хэрэглэж буй тохиодолдууд олон байна.



Бодлогын гол өөрчлөлт:

Тусламж, үйлчилгээний нийт санхүүжилт



Давуу талууд

- Даатгуулагчид эмнэлзүйн удирдамжийн дагуу, шаардлагатай тун хэмжээ, сиансаар тухайн хүнд ашигласан хэмжээнээс хамааран нэхэмжлэл илгээгдэж, иргэн болон эмнэлэг санхүүгийн бэрхшээлгүйгээр тусламж, үйлчилгээг бүрэн хүргэнэ.
- Тухайн өвчтөнд нийцсэн зөв сонголтот эмийг, зөв тунгаар эмчилгээнд ашиглах, эмчилгээний үр дүн сайжрах
- Эмнэлгүүд эмийн нэгдсэн худалдан авалтаар химийн бай эмчилгээний эм, тариаг авснаас эмнэлэг болгон ижил, хямд үнээр худалдан авна.
- Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо хэмжээний өсөлт илүү бодитой болно.
- Хими, бай эмчилгээний эмийн хэрэглээний талаарх нэгдсэн, нарийвчилсан дата мэдээлэл бий болж, хяналт илүү, сайжирна.
- ЭМД-ын сангийн үр ашиг дээшлэх, үнэтэй эм рүү хошуурах байдал цэгцрэх, эмийн тасалдалгүй байдал хангагдах.

ТОГТООЛЫН ӨӨРЧЛӨЛТ -3 ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭ

Бодлогын гол өөрчлөлт:

Эрчимт эмчилгээний тасагт эмчилгээ хийсэн ор хоногоос хамаарч эрчимт эмчилгээний төлбөрийг олгоно. Үүнд:

- Эрчимт эмчилгээний стандарт ор хоног буюу эрчимт эмчилгээний тасагт 3-6 өдөр эмчилсэн бол А,В,С,D бүлэгт хамаарах төлбөрийг олгоно.
- Эрчимт эмчилгээний тасагт 3-аас доош хоног эмчилсэн бол хоног тутамд 250.000 төгрөг хасаж олгоно.
- Эрчимт эмчилгээний тасагт 7-12 хоног эмчилсэн бол 7 дахь хоногоос хоног тутамд 250.000 төгрөг нэмж олгоно.
- Эрчимт эмчилгээний тасагт 12-оос дээш хоног эмчилсэн бол хоног тутамд 150.000 төгрөг нэмж олгоно.
- Эрчимт эмчилгээний тасагт хоног болоогүй тохиолдлыг /эмнэлэг дотор, эмнэлэг хооронд шилжсэн, нас барсан/ D бүлгийн 30 хувиар санхүүжүүлнэ.

№	Авсан арга хэмжээ	Бүлэг				
		A	B	C	D	
1	Эмийн эмчилгээ	*	*	*	*	
2	Сувилахуйн тусламж болон хяналт	*	*	*	*	
3	Эмчийн үзлэг, хяналт	*	*	*	*	
4	Лабораторийн суурь шинжилгээ /Жишээ нь: ЦЕШ, ШЕГ, биохимийн шинжилгээ, цусны бүлэгнэлт/, багажийн оношилгоо /Жишээ нь: Рентген,хэт авиа, ЗЦБ,/	*	*	*	*	
5	Шаардлагатай ажилбарыг хийсэн байх *	Төв венийн гуурс хийх				
		Гемодиализын гуурс хийх				
		Давсагны гуурсны ажилбар				
		Интубацийн гуурс хийх				
		Ходоодонд зонд тавих ажилбар				
		Артерийн судсанд гуурс байрлуулах				
		Цээжний хөндийд гуурс хийх /ТВГ/				
		Цээжний хөндийд гуурс хийх –Самбартай				
		Нугасны хөндийд хатгалт хийх	*	*	*	
		Хэвлийн хөндийд хатгалт хийх, гуурс байрлуулах				
		Үнхэлцгийн хөндийд хатгалт хийх, гуурс байрлуулах				
		Цахилгаан кардиоверси				
		Бронхоскопи, бронхосанац хийх				
		Трахейстомын гуурс хийх				
Цистостомийн гуурс хийх						
Блэйкморын зонд байрлуулах						
Гемодиализ эмчилгээ хийх						
6	Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ / MRI, СТ, уян дуран, эрчимт эмчилгээнд шаардагдах лабораторийн шинжилгээ*	*	*			
7	Ахисан түвшний ажилбар / Гавлын дотоод даралт хянах гуурс/, эрхтэн орлуулах	*				



Тулгамдсан асуудал:

1



Бүртгэгдсэн цахим мэдээлэл байхгүй

2



Эрүүл мэндийн сайд, сангийн сайдын хамтарсан 49/A118 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эсэхийг тодорхойлоогүй.

3



Эрүүл мэндийн байгууллагуудаас эмгэг судлалын шинжилгээ дээрх тушаалд байхгүй талаар санал ирүүлсэн



ICONPACKS.NET FREE ICON >

Бодлогын гол өөрчлөлт:

1



Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ + 10 төрлийн эмгэг судлалын шинжилгээ

2



Амбулаторийн цогц тусламж үйлчилгээ + 10 төрлийн эмгэг судлалын шинжилгээ



ЭМДЕГ

Санхүүжүүлэх зохицуулалт



Тулгамдсан асуудал:

Жишээлбэл:

Тархинд цус харвалтын хэвтүүлэн эмчлэх
4450 хүн 6140 тохиолдол



7.6%

Тархи, мэдрэлийн СЗТҮ авсан
338 хүн 388 тохиолдол

Өвдөг, түнхний мэс засал хийлгэсэн
1752 хүн 1906 тохиолдол



8.9%

Гэмтэл, үе мөчний СЗТҮ авсан 156 хүн 204 тохиолдол

Зүрхний мэс засал (I20-i25) хийлгэсэн
5060 хүн 5965 тохиолдол



2.9%

Сэргээн засах тусламж, үйлчилгээ авсан 150 хүн 199 тохиолдол

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо (0-16 нас)- 10,512



14%

Хэвтүүлэн сэргээн засах тусламж, үйлчилгээ авсан 1224 хүн 1617 тохиолдол

Бодлогын гол өөрчлөлт:



ДЭМБ-аас боловсруулсан бага, дунд орлоготой улс оронд зориулсан тохиолдлын тоо өндөр, хөгжлийн бэрхшээлд хүргэдэг 20 эмгэгийн СЗ тусламжийн багцыг ашигласан



Тухайн эмгэгийн сэргээн засах тусламжийн төрөл, үнэлгээ, үргэлжлэх хугацаа, эм, хэрэгсэл, давтамжаар норматив өртөг тооцсон

№	Оношийн хамааралтай бүлгийн нэр	ЭМД-аас	Иргэнээс	Нийт	ЭМД-аас	Иргэнээс	Нийт
		Хэвтүүлэн эмчлэх			Өдрөөр эмчлэх		
1	Үе мөч, тулгуур эрхтний эмгэгийн дараах сэргээн засах	720,000	150,000	870,000	290,000		290,000
2	Тархи мэдрэлийн эмгэгийн дараах сэргээн засах	1,100,000	150,000	1,250,000	395,000		395,000
3	Хорт хавдрын өвчний дараах сэргээн засах	720,000	150,000	870,000	385,000		385,000
4	Бусад өвчний дараах сэргээн засах	640,000	150,000	790,000	215,000		215,000

Тулгамдсан асуудал:

Асуудал-1: Хуулийн холбогдох заалт хүчин төгөлдөр хэвээр байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.11-т “Сувилал нь чанар, нөөц нь тогтоогдсон рашаан, байгалийн бусад хүчин зүйлийн орд газрыг ашиглан сэргээн засах болон уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх байгууллага байна.”

Асуудал-2: Гэрээний хүчинтэй хугацаа ЭМДҮЗ-ийн 02 дугаар тогтоолын дагуу 2022 онд Сувилалын байгууллагуудаас үзүүлэх тусламж, үйлчилгээг дээрх хуулийн дагуу сонгон шалгаруулалт хийж гэрээлсэн.

Асуудал-3: Ирүүлж буй санал: Одоо байгаа сэргээн засах болон уламжлалтын тусламж, үйлчилгээний ОХБ-ээр нэхэмжлэл ирүүлж байгааг ялгаж, цэгцлэх хэрэгтэй байна.

Бодлогын гол өөрчлөлт:



Сувиллын байгууллагаас үзүүлэх сувиллын тусламж, үйлчилгээ-260,000 төгрөг



Сувилаас үзүүлэх сэргээн засахын тусламж, үйлчилгээ-400,114 төгрөг



Сувилаас үзүүлэх уламжлалтын тусламж, үйлчилгээ- 416,000 төгрөг



Амбулаторийн тусламж үйлчилгээ



Хамтын төлбөрийн бодлого

- Үндсэн мэргэжлийн ЭМБ -1000 төг
- Төрөлжсөн мэргэшлийн ЭМБ-5000 төг
- Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний үед өндөр өртөгтэй оношилгоо - 30%



Оновчтой байдлын үнэлгээг санхүүжилттэй уялдуулсан

- СТ, MRI шинжилгээнд оновчтой байдлын үр дүнгээс хамаарч санхүүжилтийн урамшуулах



Шинэ технологийг дэмжсэн.

- Өдрөөр хийх хорт хавдрын шугаман хурдасгуурын аргаар хийх өндөр технологийн туяа эмчилгээ /IMRT, VMRT/



Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ




Нэхэмжлэлд даатгуулагчийн өвчний онош, үйлдлийг ICD10 болон ICD9 ангиллын дэлгэрэнгүй хувилбараар илгээнэ. Хэвтүүлэн эмчлэх бүх ТҮ үзүүлэх явцад хийгдсэн оношилгоо, шинжилгээ, эмийн эмчилгээ, ажилбарыг үйлдлийн кодоор, өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгсэлийг нэг бүрчлэн цахим системд бүртгэж нэхэмжлэлийг илгээнэ.



Шинээр төрсөн нярайд хийгдэх эрт илрүүлгийн үзлэгийн хийсэн тохиолдолд төрлөгийн үеийн ОХБ-ын төлбөр дээр холбогдох зардлыг (52.000 төгрөгөөр) нэмж санхүүжүүлэх бөгөөд хийгдсэн үзлэг, шинжилгээний үр дүнг цахим системд бүртгэж нэхэмжлэлийг ирүүлнэ.




Цочмогдуу үеийн сэргээн засахын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг ЭМБ-аас дагнасан сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага руу өвчтөн шилжүүлэх журмын дагуу шилжүүлэн эмчилсэн тохиолдлыг даатгалаас санхүүжүүлнэ.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ: САНХҮҮГИЙН ХАМГААЛАЛТ

Эрүүл мэндийн даатгалын санхүүгийн хамгаалалт хийх чадавх эрс нэмэгдсэн бөгөөд хамгийн их хамгаалалт авсан даатгуулагч 2021 онд 127.9 сая, 2022 онд 126.9 сая, 2023 онд 134.5 сая төгрөгийн тусламж, үйлчилгээний зардлыг ЭМДС-аас төлсөн байна.





ЭМД

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**